

УЛАМЖЛАЛ
ЗАН ЗАНШИЛ

УЛАМЖЛАЛ ЗАНШИЛ БҮХЭНД
УЧИР БИЙ

Г. Гунгаа

Хятадын ард түмний дотор эртнээс нааш тэмдэглэж ирсэн уламжлалт баяр олон бий. Түүний нэг нь «Дуань ү зе» (үд дундын баяр) юм. Мөн билгийн улирлын «5 сарын шинийн 5-ны баяр» ч гэж нэрлэнэ. Энэ баярын агуулга нь нэрт шүлэгч, яруу найрагч, эх оронч Чүй Юаны шударга тэмцлийг дурсан тэмдэглэх явдлаас үүдэн бий болжээ. Хятадын шүлэгч, яруу найрагч Чүй Юань (МЭӨ 340—278) бол Байлдаант улсууд (МЭӨ 403—221)-ын үеийн Чү улсын хүн юм. Чүй Юань төрийн дотоод явдлыг засах бичгийн түшмэл, гутгаар зэргийн түшмэлийн зэрэг дэвийг хүртэж, Чү улсын төрд алба хашдаг, эрдэм мэдлэг ихтэй, алсын хараатай, улс төрийн зүтгэлтэн байсны хувьд ноёд дээдсийн явдлыг нүдээр үзэж, тэр үеийн нийгмийн бурангуй ёсны эсрэг тэмцэл явуулсны учир зэмлэл шийтгэл хүлээж, юаньжян, шянжян мөрнүүдийн сав газраар (одоогийн Хунань мужийн Ми Луо сянь) удаан хугацаагаар тэнүүчлэн явах үедээ ард түмэнтэй улам ойртож, доорд ядуусын амьдралтай сайтар танилцжээ. Их шүлэгч Чүй Юань «Тэнгэрийн өчил», «Есөн бүлэгт ном», «Есөн бүлэгт дуулал», «Төр ёсны суртал», «Дургүйцэл» зэрэг 20 гаруй ном зохиол туурвижээ. Чүй Юаны зохиол бүтээлүүд нь ардын урлагийн баялаг хөрсөнд тулгуурлаж бичсэн дэвшилтэт үзэл санаа, баялаг үг хэллэгтэйн дээр тэр үеийн нийгмийн ялзран доройтож байгаа байдал, төр ёсны харгис бурангуй явдал, ноёд түшмэдийн шудрага бусыг илчилж чадсанаараа түүний үйл хэрэг өнөө үеийг хүртэл домог болтлоо уламжлагдаж, хойч үедээ сургаал болтлоо хүндлэгдсээр байгаа олон баримтыг дурьдаж болох юм.

МЭӨ 278 оны зун (билгийн улирлын 5 сарын шинийн 5-ны үд дунд), хатингардуу биетэй нэгэн өвгөн Ми Луо мөрний эрэг дээр очоод, Ми Луо мөрөнд орж үхсэн гэдэг. Энэ нь шүлэгч, яруу найрагч Чүй Юань байжээ. Чүй Юань хэдийгээр Хятадын тэр үеийн нийгэм, улс гүрнийхээ мөхөн доройтож байгаад хилэгнэн дургүйцсэн сэтгэлээ өөрийн зохиол бүтээлдээ хурцаар тусган харуулж Хятадын төр, нийгэм, ноёд дээдсийн явдлыг уран зохиолын өнгө аяст оруулан хурцаар шүүмжилсэн боловч өөрийн нь мөрөөдөл биелэгдээгүйн дээр зохиол бүтээлүүд нь дээдсийн таалалд харшилснаас болж амь эрсдэж болзошгүй болсон тул өөрийнхөө шударга тэмцлийг илэрхийлж, их мөрөнд унаж, өөрөө өөрийгөө хороох болсон нь энэ байжээ.

Энэ үеэс эхлэн жил бүрийн 5 сарын шинийн 5-нд эх оронч, шүлэгч, яруу найрагч Чүй Юань шударга үйлс, зориг санааг дурсан тэмдэглэдэг заншилтай болж улмаар «Дуань ү зе» хэмээх баярыг тэмдэглэдэг заншил бий болжээ. Ардууд энэ баяраар будаа, улаан үзэм, чавга, чихэр зэрэг амтатныг хулсны хөндийд хийж хоёр талыг нь таглан жигнэж (эсвэл чанаж) болгоод өрх гэрээрээ цуглаж будаалахын хамт хулсны хөндийд хийж болгосон идээнийхээ дээжийг гол мөрний усанд хийж хишиг өргөдөг заншилтай аж. Энэ нь голын усанд байгаа загасны хоолыг бэлтгэж өгснөөрөө Чүй Юаны цогцсыг загасанд идүүлэхгүйн бэлгэдэл болгож идээнийхээ дээжийг голын усанд өргөж байгаа зан үйл юм.

Он жил өнгөрсний эцэст амтат идээнийхээ дээжийг хулсны хөндийд хийж болгохыг больж, идээнийхээ дээжийг хулс, зэгс зэрэг ур-

гамлын навчинд ороож жигнээд «5 сарын шинийн 5-ны баяр»-аар будаалганд хэрэглэдэг заншилтай болов. Үүнийг «зунз» гэж нэрлэдэг бөгөөд энэ нь өнөө үеийг хүртэл Хятад үндэстний хоолны нэгэн төрөл болтлоо уламжлагдан иржээ.

Айл бүр энэ баяраар хийсэн «зунз»-аа өөрсдөө будаалахад хэрэглэх ба бас дээрх заншил ёсоор голын усанд хийж хишиг өргөнө. Одоо Хятадын ихэнх нутагт «зунз»-ыг баярын үеэр зах зээлд худалдах явдал өргөн дэлгэр болжээ. Ялангуяа Чүй Юаны төрсөн нутаг (одоогийн Хунань мужийн Ми Луо сянь)-т «5 сарын шинийн 5-ны баяр»-ыг өргөн дэлгэр тэмдэглэдэг заншилтай юм. Энэ баяраар ардууд идээнийхээ дээжээр «зунз» хийж будаалах ба хийсэн «зунз»-ыг Ми Луо мөрөнд хийж, хишиг өргөж ёслоно. Энэ өдөр нутгийн ардууд Ми Луо мөрний эргийн дагуу цугларна. Дээд зэргээр гоёж чимэглэсэн луун толгойтой завь болон онгоцны уралдаан тэмцээн зохион явуулна. Уралдаанд орох багууд завь болон онгоцоо гоёж чимэх, хурд хүчээ сорих гэж ихээхэн өрсөлдөнө. Мөрний эрэг дагуу зах зээл гаргаж худалдаа наймаа хийх, уран сайхны авьяастнууд дуулж, бүжиж, үлгэр хэлж, тууль хайлах зэргээр цугларсан олныг баясгана.

Хятад үндэстэн лууг лусын хаан гэж хүндэтгэн үздэг заншилтай юм. Энэ заншлын дагуу гол мөрөн бүрийг нэг луутай гэж үзнэ.

Хятадад таван өнгийн утас буюу туузыг нийтгэж хүүхдийн гарт уяж (зүүж) өгдөг зан үйл анх зүүн хан улсын үед бий болжээ. Таван өнгийн утас (тууз) -ыг хүүхдийн гарт зүүж өгснөөр гай зовлонг зайлуулж, хүүхдэд өвчин тусахаас болгоомжилж, урт наслахыг бэлгэдэхийн зэрэгцээгээр таван өнгийн утас (тууз)-ыг «5 сарын шинийн 5-ны баяр»-аар голын усанд хийдэг бөгөөд энэ нь голын усанд байгаа луу олон өнгийн утаснаас айгаад Чүй Юаны цогцсыг идэхгүй гэдэг утгаар энэ заншил анх бий болжээ. Энэ заншлыг Шаньдун мужид нэн өргөн тэмдэглэнэ.

Чүй Юаны эх оронч үзэл санаа, шударга үйл хэргийг газар бүр өөр өөрөөр тэмдэглэнэ. Зарим нутагт нэгэн баатар эр гарч чөтгөрийг дарж байгаагаар үлгэр домог бий болж Чүй Юаныг дурсан ярилцах явдал ч бий. Эцсийн эцэст энэ бүхэн нь агуулгын хувьд цөм Чүй Юаныг дурсан хүндэтгэж буй ард түмний сэтгэл санаанаас үүдэн гарсан зан үйл юм. Чүй Юань зохиол бүтээлээ өөдрөг үзлийн үүднээс ардын урлагийн санд тулгуурлан уран сайхны баялаг дүрслэлийг гаргаж чадсаны зэрэгцээгээр, уран зохиолын хэлний санг баяжуулж, улмаар өөрийн зохиол бүтээлээрээ Хятадын уран зохиолын түүхэнд яруу найргийн хөгжил цэцэглэлийн бат бэх суурийг тавьсан хүний нэг гэж зүй ёсоор үнэлэгддэг юм.

Чүй юань бол зөвхөн Хятадын уран зохиолын нэрт төлөөлөгч, Хятадын яруу найргийн өвөг эцэг гэж хүндлэгддэг төдийгүй, ази, дорно дахины нэрт зохиолчийн нэг юм. Ийм учраас «5 сарын шинийн 5-ны баяр»-ыг анхандаа зөвхөн Чүй Юаны төрсөн нутагт тэмдэглэдэг байсан бол сүүлдээ Хятад орон даяар тэмдэглэдэг болсон төдийгүй энэ зан үйл бусад орнуудад дэлгэрч Япон, Солонгос болон Азийн бусад орнуудад ч нэгэн адил дурсан тэмдэглэдэг болжээ.